

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: САГ-2020/02/СТА-ТЭЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Аудитор: Б.Энхжин Утас: 261740 Цахим хаяг: enkhjinb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1 Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	6
2.8.2 Авлага.....	7
2.8.3. Урьдчилгаа .....	7
2.8.4. Бараа материал .....	8
2.8.5. Бусад эргэлтийн хөрөнгө .....	8
2.8.6 Үндсэн хөрөнгө.....	9
2.8.7 Өр төлбөр.....	9
2.8.8 Засгийн газрын хувь оролцоо.....	10
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	12
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	13
2.11. Шилэн дансны мэдээлэл .....	13
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3. Менежментийн захидал.....	14
3.1. Дотоод хяналттай холбоотой асуудал.....	14
3.2 Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой асуудал .....	14
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	16
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	17
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	21
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	22

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
БНҮҮС	Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сан



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

2020.04.24 № 1432  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС,НББОУС, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

## **2. Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтыг сайжруулах, харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгэлтэй он удаан жил болсон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, бусад эргэлтийн хөрөнгийг ашиглагч байгууллагууд руу шилжүүлэх талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 06-наас 2020 оны 04 дүгээр сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор Б.Энхжин гүйцэтгэв.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн ХЭГ/868 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Монгол Улсын Ерөнхий сайд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн 1-д “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна” гэж заасны дагуу яам, Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ чиглэлээр цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих хяналт, шалгалт, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хийх хяналт, шинжилгээ, үр дүнд өгөх үнэлгээний үр ашгийг дээшлүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах зэрэг үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч УСНББОУС, түүнд нийцүүлэн дараах хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Засгийн газрын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль

#### **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт хөрөнгөөр сонгосон нь “Монгол шуудан” ХК-ийн санхүүгийн тайланг төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэсэнтэй холбоотойгоор нийт хөрөнгө 282,410.4 сая төгрөгөөр өссөн тул нийт хөрөнгийг сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 1,139,859.3 сая төгрөгийн 2 хувь буюу 22,797.2 сая төгрөгөөр тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

## 2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

### 2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 47,144.8 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 68,779.1 сая төгрөг болж, 21,634.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	70.1	41.7	-28.4
Банканд байгаа бэлэн мөнгө	47,063.5	68,709.8	21,646.3
Замд яваа мөнгөн хөрөнгө	11.2	27.6	16.4
<b>Дүн</b>	<b>47,144.8</b>	<b>68,779.1</b>	<b>21,634.3</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	24,614.0	28,365.2	3,751.2
Төсөл хөтөлбөрийн нэгж	0.5	0.0	-0.5
Засгийн газрын тусгай сан	43.6	70.6	27.0
ТӨҮГ	22,486.7	40,343.3	17,856.6
<b>Дүн</b>	<b>47,144.8</b>	<b>68,779.1</b>	<b>21,634.3</b>

*Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт мөнгөн хөрөнгийн 99.9 хувь буюу 68,709.8 сая төгрөгийг банканд байгаа бэлэн мөнгө эзэлж байна. Үүнээс 28,360.4 сая төгрөг төсөвт байгууллагын, 70.6 сая төгрөг Засгийн газрын тусгай сангийн, 40,278.8 сая төгрөг төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын үлдэгдэл байна.

Мөнгөн хөрөнгө өмнөх оноос 21,634.3 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2018 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу төрийн өмчийн 66 хувийн оролцоотой “Монгол шуудан” ХК-ийн санхүүгийн тайланг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэсэнтэй холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:*

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 229 дүгээр тогтоолоор баталсан Улсын төсөвт төвлөрүүлбэл зохих ногдол ашгийг “МИАТ” ХК 7,335.1 сая төгрөгөөр, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ 59.6 сая төгрөгөөр тус тус дутуу төвлөрүүлсэн байна.
- Үндэсний хөгжлийн газар төслийн техникийн хяналтаас хэмнэгдсэн 2,987.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, концессын гэрээний 3.13.1-т заасан

концесс эзэмшигчээс концесс олгогчид төлөх 1,452.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй,

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 3.6 сая төгрөг, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар 100.0 сая төгрөг, Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сан 9.9 сая төгрөгийн он удаан жил болсон барьцаа хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй,

“Монгол шуудан” ХК 35.4 сая төгрөгийн цалин илүү олгосон, 4.4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл илүү төлсөн, 3.2 сая төгрөгийн ХХОАТ дутуу суутгасан зэрэг алдаа зөрчил илэрсэн байна.

## 2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 12,157.5 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 17,809.5 сая төгрөг болж, 5,652.0 сая төгрөг буюу 46.5 хувиар өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	9.7	20.0	10.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	4,465.6	3,718.9	-746.7
Татаас, санхүүжилтийн авлага	32.6	512.9	480.3
Дансны авлага /ТӨҮГ/	5,482.3	10,758.1	5,275.8
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	196.2	37.5	-158.7
Бусад авлага	1,971.1	2,762.1	791.0
<b>Дүн</b>	<b>12,157.5</b>	<b>17,809.5</b>	<b>5,652.0</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	521.4	800.0	278.6
Төсөл хөтөлбөрийн нэгж	0.7	0.1	-0.6
Засгийн газрын тусгай сан	973.7	1,330.3	356.6
ТӨҮГ	10,661.7	15,679.1	5,017.4
<b>Дүн</b>	<b>12,157.5</b>	<b>17,809.5</b>	<b>5,652.0</b>

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын эцсийн үлдэгдэл 5,652.0 сая төгрөгөөр өссөний 76.8 хувь нь “Монгол шуудан” ХК-ийн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад авлагатай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 64.9 сая төгрөг, Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сан 239.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
- “Монгол шуудан” ХК найдваргүй авлагад байгуулсан нөөцийг данснаас хасаагүй,
- “Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨҮГ-ын Санхүүгийн тайланд бүртгэлтэй 6.7 сая төгрөгийн 6-аас дээш жилийн насжилттай авлага байна.

## 2.8.3. Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 9,846.2 сая төгрөгийн байсан бол эцсийн үлдэгдэл 12,375.6 сая төгрөг болж, 2,529.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	3,188.6	9,211.5	6,022.9
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	819.8	2,040.6	1,220.8
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	5,823.3	1,094.5	-4,728.8
Цалингийн урьдчилгаа	3.2	3.6	0.4
Томилолтын урьдчилгаа	11.3	25.4	14.1
<b>Дүн</b>	<b>9,846.2</b>	<b>12,375.6</b>	<b>2,529.4</b>



<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	2,313.4	6,887.2	4,573.8
Төсөл хөтөлбөрийн нэгж	2,677.2	2,676.2	-1.0
ТӨҮГ	4,855.6	2,812.2	-2,043.4
<b>Дүн</b>	<b>9,846.2</b>	<b>12,375.6</b>	<b>2,529.4</b>

*Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдлийн 55.6 хувь нь төсөвт байгууллагын дүн буюу Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын он дамжин хэрэгжих хөтөлбөр арга хэмжээний урьдчилж гарсан зардал 6,000.0 сая төгрөг байна.

#### 2.8.4. Бараа материал

Бараа материалын эцсийн үлдэгдэл 21,369.1 сая төгрөг болж, 69,705.7 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	5,021.1	5,213.7	192.6
Дуусаагүй үйлдвэрлэл	73,281.0	43.1	-73,237.9
Бэлэн бүтээгдэхүүн	487.2	1,351.2	864.0
Хангамжийн материал	12,234.8	14,711.8	2,477.0
Мал амьтад	50.7	49.3	-1.4
<b>Дүн</b>	<b>91,074.8</b>	<b>21,369.1</b>	<b>-69,705.7</b>

*Үүнээс, байгууллагын төрлөөр*

Төсөвт байгууллага	32,450.4	10,962.7	-21,487.7
Төсөл хөтөлбөрийн нэгж	40,351.9	0.0	-40,351.9
Засгийн газрын тусгай сан	9,808.1	0.0	-9,808.1
ТӨҮГ	8,464.4	10,406.4	1,942.0
<b>Дүн</b>	<b>91,074.8</b>	<b>21,369.1</b>	<b>-69,705.7</b>

*Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын эцсийн үлдэгдэл 69,705.7 сая төгрөгөөр буурсан нь Төсөвт байгууллагын дуусаагүй үйлдвэрлэл 21,487.7 сая, төсөл хөтөлбөрийн дуусаагүй үйлдвэрлэл 40,351.9 сая, засгийн газрын тусгай сангийн дуусаагүй үйлдвэрлэл 9,808.1 сая төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Энэ нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, бусад биет ба биет бус хөрөнгийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн байсныг төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулж бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэсэнтэй холбоотой.

#### 2.8.5. Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө данс 547,218.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт №5 Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад санхүүгийн хөрөнгө /ТӨҮГ/	0.0	7,041.8	7,041.8
Бусад эргэлтийн хөрөнгө	0.0	540,176.2	540,176.2
<b>Дүн</b>	<b>0.0</b>	<b>547,218.0</b>	<b>547,218.0</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	0.0	490,194.4	490,194.4
Төсөл хөтөлбөрийн нэгж	0.0	40,347.0	40,347.0
Засгийн газрын тусгай сан	0.0	9,634.8	9,634.8
ТӨҮГ	0.0	7,041.8	7,041.8
<b>Дүн</b>	<b>0.0</b>	<b>547,218.0</b>	<b>547,218.0</b>

*Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бусад эргэлтийн хөрөнгө дансны 490,194.4 сая төгрөгийн үлдэгдэл нь төсөвт байгууллагын концессын гэрээний дагуу хэрэгжүүлсэн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон дуусаагүй барилга байгууламж болон ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй хөрөнгө оруулалт, 7,041.8 сая төгрөг нь Мэдээлэл холбооны сүлжээ ХК болон Монголын цахилгаан холбоо ХК-ийн урт хугацаатай арилжааны банканд хадгалуулсан хадгаламж байна.

*Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:*

- *Бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сан, Мэдээлэл харилцаа холбооны шинэчлэлийн төслийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.*

## 2.8.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 472,307.6 сая төгрөг болж, 291,086.6 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	551,243.1	330,476.6	-220,766.5
Биет бус хөрөнгө	134,874.5	136,465.1	1,590.6
Бусад хөрөнгө	5,276.6	5,365.9	89.3
<b>Дүн</b>	<b>691,394.2</b>	<b>472,307.6</b>	<b>-219,086.6</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	434,962.0	155,720.0	-279,242.0
Төсөл хөтөлбөрийн нэгж	52.5	29.8	-22.7
Засгийн газрын тусгай сан	19.5	15.8	-3.7
ТӨҮГ	256,360.2	316,542.0	60,181.8
<b>Дүн</b>	<b>691,394.2</b>	<b>472,307.6</b>	<b>-219,086.6</b>

*Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсөвт байгууллагын үндсэн хөрөнгө 279,242.0 сая төгрөгөөр буурч, ТӨҮГ-ын үндсэн хөрөнгө 60,181.8 сая төгрөгөөр өссөн байна.

Төсөвт байгууллагын үндсэн хөрөнгө 279,242.0 сая төгрөгөөр буурсан нь концессын гэрээний дагуу барьж байгуулсан барилга, зам гүүрийн байгууламж, тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бүртгэснийг залруулж бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэсэнтэй холбоотой.

*Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад үндсэн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:*

- *Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 47.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар ашиглаж байна.*
- *“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК актлагдсан үндсэн хөрөнгөд 0.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг илүү тооцоолсон байна.*
- *“Монгол шуудан” ХК үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллогын тайланг ирүүлсэн боловч эд хөрөнгийн тооллогын хугацааг баримтлаагүй, эд хөрөнгө тоолох журамгүй зэрэг зөрчил илэрлээ.*

## 2.8.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 70,311 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 125,310.1 сая төгрөг болж, 54,998.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+) Буурсан (-)
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	17,963.9	31,326.5	13,362.6
Богино хугацаат зээлийн өглөг	0.0	1,406.8	1,406.8
Өглөг	15,260.2	25,642.5	10,382.3
Урьдчилж орсон орлого	2,703.7	4,277.2	1,573.5
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>	52,347.3	93,983.6	41,636.3
Урт хугацаат зээл	52,347.3	93,983.6	41,636.3
<b>Нийт дүн</b>	<b>70,311.2</b>	<b>125,310.1</b>	<b>54,998.9</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	9,232.3	9,981.4	749.1
Төсөл, сан	0.7	0.7	0.0
Засгийн газрын тусгай сан	46.6	156.1	109.5
ТӨҮГ	61,031.5	115,171.8	54,140.3
<b>ДҮН</b>	<b>70,311.2</b>	<b>125,310.1</b>	<b>54,998.9</b>

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 17,963.9 сая, эцсийн үлдэгдэл 31,326.5 сая төгрөг болж, 13,362.6 сая төгрөгөөр өссөн нь “Монгол шуудан” ХК-ийн богино хугацаат өр төлбөр 10,560.9 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр эхний үлдэгдэл 52,347.3 сая, эцсийн үлдэгдэл 93,983.6 сая төгрөг болж, 40,636.3 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨҮГ-ын урт хугацаат өр төлбөр 0.5 сая төгрөгөөр буурч, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн урт хугацаат өр төлбөр 41,636.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 195.3 сая төгрөг, Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сан 51.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

**2.8.8 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,011,163.3 сая төгрөг болж, 224,025.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	141,415.2	139,989.3	-1,425.9
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	141,058.7	147,631.4	6,572.7
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	137.1	137.1	0.0
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	0.0	2,538.5	2,538.5
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	50,236.9	55,197.5	4,960.6
Өмнөх үеийн үр дүн	336,224.8	415,873.0	79,648.2
Тайлант үеийн үр дүн	75,885.0	204,032.4	128,147.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	42,180.0	45,764.1	3,584.1
<b>Дүн</b>	<b>787,137.7</b>	<b>1,011,163.3</b>	<b>224,025.6</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	485,628.9	682,947.9	197,319.0
Төсөл хөтөлбөрийн нэгж	43,082.1	43,052.4	-29.7
Засгийн газрын тусгай сан	10,798.2	10,895.4	97.2
ТӨҮГ	247,628.5	274,267.6	26,639.1
<b>Дүн</b>	<b>787,137.7</b>	<b>1,011,163.3</b>	<b>224,025.6</b>

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан өмнөх оноос

1,425.9 сая төгрөгөөр буурсан нь Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн тайланд газрын дахин үнэлгээний дүн 1,425.9 сая төгрөгөөр Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан дансыг нэмэгдүүлснийг тайлант оны төсвийн шууд захирагчийн аудитаар залруулж эздийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэж залруулсантай холбоотой байна.

Засгийн газрын 2018 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу төрийн өмчийн 66 хувийн оролцоотой “Монгол шуудан” ХК-ийн санхүүгийн тайланг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэсэнтэй холбоотойгоор төрийн өмч 6,572.7 сая төгрөгөөр, нэмж төлөгдсөн капитал 2,538.5 сая төгрөгөөр, эздийн өмчийн бусад хэсэг 2,710.1 сая төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 3,379.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар 317,400.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 162,226.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 51.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт № 9 Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	3,000.0	3,165.6	165.6	105.5
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	310,870.0	155,232.2	-155,567.8	49.9
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	3,600.4	3,829.1	228.7	106.4
<b>Нийт дүн</b>	<b>317,400.4</b>	<b>162,226.9</b>	<b>-155,173.5</b>	<b>51.1</b>

Төрийн өмчид ноогдох хувьцааны ноогдол ашиг 155,567.8 сая төгрөгөөр тасарсан нь:

- Засгийн газрын 2019 оны 4 сарын 10-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр “Эрдэнэс таван толгой” ХК-ын ногдол ашиг хуваарилах талаар гаргасан ТУЗ-ийн 2019 оны 03 дугаар тогтоолыг хүчингүй болгосон, “Эрдэнэс Монгол”ХХК, “Багануур” ХК улсын төсөвт ноогдол ашгийн орлого төвлөрүүлэх боломжгүй зэрэг шалтгаанаар “Ирээдүйн өв сан”-д төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 149,231.4 сая төгрөгөөр,
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 05 сарын 21-ний өдрийн 229 дүгээр тогтоолоор Төрийн өмчид ноогдох хувьцааны ноогдол ашиг 11,172.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас 7,509.0 сая төгрөгийг тус тус дутуу төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 308,030.0 сая төгрөгийн төсөв батлагджээ. Нийт зардлын 304,429.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 3,600.4 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 295,440.1 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 20,031.7 сая төгрөгийн орлого, нийт 315,471.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 298,667.2 сая төгрөгийг зарцуулж 16,804.6 сая төгрөгийн улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 298,667.2 сая төгрөг буюу 97.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс урсгал үйл ажиллагааны зардалд 99,964.0 сая төгрөг, хөрөнгийн зардалд 198,703.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 206,541.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 198,703.1 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтөд 12 төсөл, арга хэмжээнд 144,699.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 137,364.4 сая төгрөгийг зарцуулсан нь Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн 220 кв-ын хоёр хэлхээт ЦДАШ, дэд станцын санхүүжилтийг шаардлага хангаагүйн улмаас концессын эргэн төлөлт хийгдээгүйтэй холбоотой байна.

## **2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн байгууллага 8, төрийн өмчит аж ахуйн нэгж 7, Засгийн газрын тусгай сан 1, төсөл хөтөлбөрийн нэгжийн 2, нийт 18 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 7 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, 10 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 591,833.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 574,057.3 сая төгрөгийн алдааг залруулж, 11,996.0 сая төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 3,384.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 25 албан шаардлага хүргүүлж, 2,395.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 81 зөвлөмж өглөө.

### Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 3,356.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 342.9 сая төгрөгийн алдааг залруулж, 5.4 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 2,018.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 8 албан шаардлага хүргүүлж, 989.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 36 зөвлөмж өглөө.

### Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 3 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 510,556.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 496,721.8 сая төгрөгийн алдааг залруулж, 11,937.5 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 877.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлж, 1,019.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 16 зөвлөмж өглөө.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актаас 4,439.2 сая төгрөгийг аудитын явцад барагдуулж улсын төсөвт төвлөрүүлсэн.

### Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төрийн өмчит 7 аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 8,634.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 8,007.1 сая төгрөгийн алдааг залруулж, 43.1 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 197.7 сая төгрөгийн

зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлж, 386.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 27 зөвлөмж өглөө.

#### Засгийн газрын тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сангийн 2019 оны санхүүгийн тайланг түүвэрт хамруулж нийт 28,939.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 28,638.4 сая төгрөгийн алдааг залруулж, 9.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 291.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүллээ.

#### Төсөл, хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 2 төсөл хөтөлбөрийн нэгжийг түүвэрт хамруулж аудитын үе шатны ажилбарыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 40,347.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснийг санхүүгийн тайланд залрууллаа.

### **2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын байгууллагууд 2019 онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 107 мэдээллийг хугацаанд нь, 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид зөвлөмж өгөөгүй.

### **2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 17,776.5 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 22,797.2 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул “Зөрчилгүй” дүгнэлтийг өгч байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Дотоод хяналттай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дотоод хяналт хангалтгүйгээс төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил өмнөх жилээс нэмэгдэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10-т "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Дотоод хяналт сул, холбогдох хууль, журам, зааврыг хэрэгжүүлж ажиллаагүй байх;

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналт, дээд шатны төсөв захирагчаас санхүүгийн тайлан, улсын төсвийн орлого төвлөрүүлэлт, төсвийн төлөвлөлт, зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### **3.2 Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 4.1.4-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

### 3.2.2 Эрсдэл:

Хөрөнгийн үнэ цэнэ буурах, хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүйгээс өмчид тавих хяналт сулрах, хөрөнгө шамшигдах, алдагдах;

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн он удаан жил болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, биет ба биет бус хөрөнгийг ашиглагч байгууллагууд руу шилжүүлэх.

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



#### 4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	166,054,762.9	667,551,229.2
31	Мөнгөн хөрөнгө	47,144,797.4	68,779,108.6
32	Богино хугацаат хөрөнгө оруулалт	5,831,510.4	-
33	Авлага	12,157,481.2	17,809,490.6
34	Урьдчилгаа	9,846,197.7	12,375,578.4
35	Бараа материал	91,074,776.3	21,369,070.8
36	Нөөцийн бараа	-	-
360	Бусад эргэлтийн хөрөнгө	-	547,217,980.7
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	691,394,186.6	472,308,080.7
37	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	500.0
37200	Үнэт цаас	-	500.0
39	Үндсэн хөрөнгө	691,394,186.6	472,307,580.7
39200	Биет хөрөнгө	551,243,105.3	330,476,636.6
39300	Биет бус хөрөнгө	134,874,524.4	136,465,057.7
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	5,276,556.9	5,365,886.4
3	Нийт хөрөнгийн дүн iii=i+ii	857,448,949.4	1,139,859,309.9
4	Нийт өр төлбөр	70,311,227.9	125,310,075.5
41	Богино хугацаат өр төлбөр	17,963,890.4	31,326,473.7
41200	Богино хугацаат зээлийн өглөг	-	1,406,848.8
41300	Өглөг	15,260,170.3	25,642,457.7
41400	Урьдчилж орсон орлого	2,703,720.1	4,277,167.2
42	Урт хугацаат өр төлбөр	52,347,337.5	93,983,601.8
42200	Урт хугацаат зээл	52,347,337.5	93,983,601.8
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	787,137,721.6	1,014,549,234.4
51	Засгийн газрын хувь оролцоо	787,137,721.6	1,011,163,298.1
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	141,415,250.3	139,989,278.1
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	141,058,709.2	147,631,409.2
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	137,098.9	137,098.9
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	-	2,538,512.2
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	50,236,843.7	55,197,475.2
51200	Хуримтлагдсан үр дүн	412,109,775.8	619,905,415.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	42,180,043.7	45,764,109.6
52	Хяналтын бус хувь оролцоо	-	3,385,936.3
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн vi=iv+v	857,448,949.4	1,139,859,309.9

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	Үйл ажиллагааны орлогын дүн (i)	278,319,262.5	514,279,940.3
12	Татварын бус орлого	93,495,001.8	216,425,983.4
120	Нийтлэг татварын бус орлого	92,772,869.3	215,968,223.9
121	Хөрөнгийн орлого	708,904.5	434,353.8
122	Тусламжийн орлого	13,228.0	23,405.7
13	Тусламж, санхүүжилтийн орлого	184,824,260.7	297,853,956.9
II	Үйл ажиллагааны зардлын дүн	182,240,699.9	305,791,192.1
21	Урсгал зардал	182,213,699.9	305,791,192.1
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	127,155,035.2	140,718,729.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,765,856.3	50,726,937.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,191,250.3	2,468,718.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,644,752.7	1,803,722.8
2104	Хангамж, бараа материалын зардал	1,064,798.5	1,216,022.3
2105	Нормативт зардал	32,578.6	69,530.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	921,389.7	1,391,795.0
2107	Томилолт, зочны зардал	669,181.7	619,618.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,718,272.2	15,109,546.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,146,955.2	67,312,837.8
212	Татаас	1,590,000.0	695,375.0
213	Урсгал шилжүүлэг	53,468,664.8	164,377,087.5
22	Хөрөнгийн зардал	27,000.0	-
III	Үйл ажиллагааны үр дүн (iii)=(i)-(ii)	96,078,562.5	208,488,748.2
IV	Үйл ажиллагааны бус орлогын дүн	144,971.8	451,989.3
V	Үйл ажиллагааны бус зардлын дүн	20,338,581.1	4,908,303.8
VI	Үйл ажиллагааны нийт үр дүн (vi)=(iii)+(iv)-(v)	75,884,953.2	204,032,433.6

#### 4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн (i)	337,901,664.8	632,865,713.6
12	Татварын бус орлого	152,013,403.6	317,438,629.3
120	Нийтлэг татварын бус орлого	151,304,499.1	316,982,628.8
121	Хөрөнгийн орлого	708,904.5	434,353.8
122	Тусламжийн орлого	-	21,646.7
13	Тусламж, санхүүжилтийн орлого	185,888,261.1	315,427,084.3
II	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	204,918,202.2	375,696,628.0
21	Урсгал зардал	204,918,202.2	375,696,628.0
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	146,301,382.6	206,410,072.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	63,504,873.6	76,303,186.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,858,271.6	9,848,976.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,921,670.8	23,653,711.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5,762,190.0	10,478,800.3
2105	Нормативт зардал	47,414.9	64,626.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,656,151.2	1,710,106.6
2107	Томилолт, зочны зардал	685,653.1	629,724.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,320,063.5	53,526,106.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,545,093.8	30,194,834.5
212	Татаас	4,187,820.4	3,774,715.0
213	Урсгал шилжүүлэг	54,428,999.1	165,511,840.6
III	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (iii)=(i)-(ii)	132,983,462.6	257,169,085.7
IV	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн (iv)	878,954.9	2,080,828.8
V	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн (v)	123,476,629.8	237,624,893.2
22	Хөрөнгийн зардал	123,476,629.8	237,624,893.2
2200	Дотоод эх үүсвэрээр	123,476,629.8	237,624,893.2
VI	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ (vi)=(iv)-(v)	-122,597,675.0	-235,544,064.4
VII	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-855,470.7	9,290.0
14	Бусад эх үүсвэр	1,301,373.1	1,005,769.4
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	2,156,843.8	996,479.3
VIII	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ (viii)=(iii)+(vi)+(vii)	9,530,316.9	21,634,311.3
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	37,614,480.4	47,144,797.4
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	47,144,797.4	68,779,108.6

#### 4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	531,273,041.1	-	531,273,041.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	19,977,012.2	-	19,977,012.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	551,250,053.2	-	551,250,053.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	33,638,738.2	-	33,638,738.2
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	9,219,456.8	-	9,219,456.8
Өмчид гарсан өөрчилөлт	117,359,220.3	-	117,359,220.3
Зарласан ногдол ашиг	-214,700.1	-	- 214,700.1
Тайлант үеийн үр дүн	75,884,953.2	-	75,884,953.2
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	787,137,721.6	-	787,137,721.6
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	787,137,721.6	-	787,137,721.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	23,100,754.1	-	23,100,754.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	810,238,475.7	-	810,238,475.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	279,532.1	-	279,532.1
Өмчид гарсан өөрчилөлт	841,047.6	-	841,047.6
Зарласан ногдол ашиг	-842,254.6	-	-842,254.6
Тайлант үеийн үр дүн	204,032,433.6	-	204,032,433.6
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,014,549,234.4	-	1,014,549,234.4

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	308,030,038.0	298,667,166.3	9,362,871.7	97.0
Урсгал зардал	101,488,502.3	99,964,051.2	1,524,451.1	98.5
Бараа, ажил үйлчилгээний зардал	91,370,758.7	90,806,082.7	564,676.0	99.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,552,649.9	45,526,014.4	26,635.5	99.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,730,881.2	1,724,962.6	5,918.6	99.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	735,940.5	612,059.1	123,881.4	83.2
Хангамж, бараа материалын зардал	547,194.1	546,924.6	269.5	100.0
Нормативт зардал	282.6	132.6	150.0	46.9
Эд хогшил, урсгал засварын зардал	971,773.4	971,726.0	47.4	100.0
Томилолт, зочны зардал	187,028.2	183,925.7	3,102.5	98.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,502,662.3	3,246,025.2	256,637.1	92.7
Бараа үйлчилгээний бусад зардал	38,142,346.5	37,994,312.5	148,034.0	99.6
Татаас	7,964,315.7	7,055,067.0	909,248.7	88.6
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,429,952.0	4,429,952.0	-	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,534,363.7	2,625,115.0	909,248.7	74.3
Урсгал шилжүүлэг	2,153,427.9	2,102,901.5	50,526.4	97.7
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,935,385.1	1,915,840.3	19,544.8	99.0
Бусад урсгал шилжүүлэг	218,042.8	187,061.2	30,981.6	85.8
Хөрөнгийн зардал	206,541,535.7	198,703,115.1	7,838,420.6	96.2
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	308,030,038.0	298,686,582.0	9,343,456.0	97.0
Улсын төсвөөс санхүүжих	304,429,665.6	294,857,449.2	9,572,216.4	96.9
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	3,600,372.4	3,829,132.8	-228,760.4	106.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,961.9	-1,961.9	
Төсвийн бусад мэдээллийн ангилал	789	789	-	100.0
Байгууллагын тоо	5	5	-	
Ажиллагсадын тоо	392	392	-	100.0
Орон тооны мэдээлэл	392	392	-	100.0

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		2,824,779.6
Урсгал зардал		2,702,544.6
Бараа, ажил үйлчилгээний зардал		2,421,524.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		88,836.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		11,208.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		10,641.2
Хангамж, бараа материалын зардал		35,251.1
Нормативт зардал		39,690.0
Эд хогшил, урсгал засварын зардал		213,973.5
Томилолт, зочны зардал		43,088.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		63,060.0
Бараа үйлчилгээний бусад зардал		1,915,775.8
Урсгал шилжүүлэг		281,020.4
Бусад урсгал шилжүүлэг		91,600.0
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		189,420.4
Хөрөнгийн зардал		122,235.0
Дотоод эх үүсвэрээр		122,235.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		2,824,779.6
Нэмэлт санхүүжилтийн орлого		2,824,779.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		217,364.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		217,364.9

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Д/д	Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр						Нийт зөрчил		Залруулсан алдаа		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Итгэл	Түүвэрт	Зөрчилгүй	Угсаагүй	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>11</b>	<b>12</b>	<b>13</b>	<b>14</b>	<b>15</b>	<b>16</b>	<b>17</b>	<b>18</b>
<b>ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ</b>																	
1	Ерөнхий сайд			1				2	0							2	-
1	<b>ДҮН</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>
<b>ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ</b>																	
1	Тагнуулын ерөнхий газар				1			48	3,356.7	2	342.9	2	5.4	8	2,018.5	36	989.9
1	<b>ДҮН</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>48</b>	<b>3,356.7</b>	<b>2</b>	<b>342.9</b>	<b>2</b>	<b>5.4</b>	<b>8</b>	<b>2,018.5</b>	<b>36</b>	<b>989.9</b>
<b>ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ</b>																	
1	Монголын цахилгаан холбоо ХК			1				4	184.1	1	178.7					3	5.4
2	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК			1				8	281.5	1	22.8					7	258.7
3	Үндэсний дата төв УТҮГ			1				2	35.9	0	-	0	-	1	35.9	1	-
4	Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ			1				3	43.2	0	-	0	-	1	6.7	2	36.5
5	Монгол шуудан ХК			1				15	458.9	1	394.0	2	43.1	5	21.8	7	-
6	Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ			1				7	46.8	2	6.9	0	-	1	20.0	4	19.9
7	Харилцаа холбооны зохицуулах хороо			1				11	7,584.1	7	7,404.7	0	-	1	113.3	3	66.1
7	<b>ДҮН</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>7</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>50</b>	<b>8,634.5</b>	<b>12</b>	<b>8,007.1</b>	<b>2</b>	<b>43.1</b>	<b>9</b>	<b>197.7</b>	<b>27</b>	<b>386.6</b>
<b>ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ</b>																	

1	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар			1				11	8,807.9	2	467.5	3	7,398.3	1	595.5	5	346.6
2	Үндэсний хөгжлийн газар			1				11	468,167.7	1	463,220.9	2	4,439.2	2	91.1	6	416.5
3	МОНЦАМЭ агентлаг			1				5	18.9	1	7.5	0	-	1	-	3	11.4
4	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар		1					7	60,482.6	2	32,973.4	1	100.0	2	191.1	2	244.7
5	Цөмийн энергийн комисс		1					1	12.0	1	12.0						
6	Жендэрийн үндэсний хороо		1					2	40.5	2	40.5						
7	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга		1					0	-	0	-						
<b>7</b>	<b>ДҮН</b>	<b>0</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>37</b>	<b>510,556.2</b>	<b>9</b>	<b>496,721.8</b>	<b>6</b>	<b>11,937.5</b>	<b>6</b>	<b>877.7</b>	<b>16</b>	<b>1,019.2</b>
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН</b>																	
1	Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сан		1					8	28,939.3	5	28,638.4	1	9.9	2	291.0	0	-
<b>1</b>	<b>ДҮН</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>8</b>	<b>28,939.3</b>	<b>5</b>	<b>28,638.4</b>	<b>1</b>	<b>9.9</b>	<b>2</b>	<b>291.0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН НЭГЖ</b>																	
1	МХХСүлжээний шинэчлэл төсөл		1					1	40,347.1	1	40,347.1						
2	Шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт		1					0	-								
<b>2</b>	<b>ДҮН</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>40,347.1</b>	<b>1</b>	<b>40,347.1</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>
<b>НИЙТ ДҮН</b>		<b>0</b>	<b>7</b>	<b>11</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>146</b>	<b>591,833.8</b>	<b>29</b>	<b>574,057.3</b>	<b>11</b>	<b>11,995.9</b>	<b>25</b>	<b>3,384.9</b>	<b>81</b>	<b>2,395.7</b>



Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн актын нэгтгэл

№	Харьяа байгууллага	Төлбөрийн актын товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
<b>ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ</b>					
1	"Монгол шуудан" ХК	Тайлант хугацаанд нийт 8 ажилтанд анхан шатны баримтгүйгээр 35.4 сая төгрөгийн цалин олгосон байна. Үүнтэй холбоотойгоор аж ахуйн нэгжээс 4.4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна.	39.8	1. Гүйцэтгэх захирал, 2. Санхүүгийн газрын захирал	1. Б.Анхбаатар 2. Б.Наранцэцэг
2		Тайлант хугацаанд ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалингаас 3.2 сая төгрөгийн ХХОАТ дутуу суутгасан байна.	3.2	1. Гүйцэтгэх захирал, 2. Санхүүгийн газрын захирал	1. Б.Анхбаатар 2. Б.Наранцэцэг
<b>ДҮН</b>			<b>43.0</b>		
<b>НИЙТ ДҮН</b>			<b>43.0</b>		
<b>ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ</b>					
1		Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 229 дүгээр тогтоолоор баталсан Улсын төсөвт төвлөрүүлбэл зохих ногдол ашгийг "МИАТ" ХК 7,335.1 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.	7,335.1	1. Дарга 2. Ахлах нягтлан бодогч	1. З.Мэндсайхан 2. Ж.Мөнхтүвшин
2	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 229 дүгээр тогтоолоор баталсан Улсын төсөвт төвлөрүүлбэл зохих ногдол ашгийг "Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв" ТӨҮГ 59.6 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.	59.6	1. Дарга 2. Ахлах нягтлан бодогч	1. З.Мэндсайхан 2. Ж.Мөнхтүвшин
3		Тайлант онд Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээний 10.2-т заасны дагуу түрээсийн гэрээг цуцлах хүсэлт гаргасан 3 аж ахуйн нэгж, байгууллагын түрээсийн барьцаа төлбөр 3.6 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн данснаас Улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	3.6	1. Дарга 2. Ахлах нягтлан бодогч	1. З.Мэндсайхан 2. Ж.Мөнхтүвшин
<b>ДҮН</b>			<b>7,398.3</b>		
4	Үндэсний хөгжлийн газар	Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төслийн техникийн хяналтаас хэмнэгдсэн 2,987.0 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	2,987.0	1. Дарга 2. Ахлах нягтлан бодогч	1. Б.Баярсайхан 2. Г.Түвшинтөгс
5		"Багануурын цахилгаан станц" төслийн концессын гэрээний 3.13.1-т заасан концесс эзэмшигчээс концесс олгогчид төлөх 3.0 сая ам.долларын концессын төлбөрийн 3 дахь төлөлт 1,452.2 сая төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	1,452.2	1. Дарга 2. Ахлах нягтлан бодогч	1. Б.Баярсайхан 2. Г.Түвшинтөгс
<b>ДҮН</b>			<b>4,439.2</b>		

	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	Барьцаа хөрөнгийн дансанд 100.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг 2012 оноос хойш байршуулж байна.	100.0	1. Дарга 2. нягтлан бодогч	1. Б.Чинбат 2.О.Наранбаатар
<b>ДҮН</b>			<b>100.0</b>		
<b>НИЙТ ДҮН</b>			<b>11,937.5</b>		
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН</b>					
1	Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сан	Барьцаа хөрөнгийн дансанд байршиж буй 9.9 сая төгрөгийг байгууллагад өгөх өглөгөөр бүртгээгүй, 2012 оноос хойш барьцаа хөрөнгийн дансанд байршсан байна.	9.9	1. Дарга 2. Нягтлаг бодогч	1. Ч.Цогтгэрэл 2. Т.Халиунаа
<b>ДҮН</b>			<b>9.9</b>		
<b>НИЙТ ДҮН</b>			<b>9.9</b>		
<b>НИЙТ ТӨЛБӨРИЙН АКТЫН ДҮН</b>			<b>11,990.4</b>		

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хүргүүлсэн албан шаардлагын нэгтгэл

№	Харьяа байгууллага	Төлбөрийн актын товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
<b>ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ</b>					
1	"Монгол шуудан" ХК	Харилцагч байгууллагатай авлага, өглөгийн тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулалт хангалттай хийгдээгүй байна.	-	1. Гүйцэтгэх захирал, 2. Санхүүгийн газрын захирал	1. Б.Анхбаатар 2. Б.Наранцэцэг
2	"Монгол шуудан" ХК	Авто тээврийн үндэсний төвөөс ирүүлсэн компанийн эзэмшилд байгаа тээврийн хэрэгслийн лавлагаагаар нийт 162 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа боловч компанийн бүртгэлээр 141 тээврийн хэрэгсэл байна. Үүний 5 машин нь компанийн нэр дээр бүртгэлгүй, 27 машин нь компанийн бүртгэлд байхгүй байна.	-	1. Гүйцэтгэх захирал, 2. Санхүүгийн газрын захирал	1. Б.Анхбаатар 2. Б.Наранцэцэг
3	"Монгол шуудан" ХК	Идеал Групп" ХХК-д төлсөн 21.8 сая төгрөгийн барилгын зураг төслийн ажлын мөнгийг 2009 онд Урьдчилж төлсөн зардлаар бүртгэснийг залруулах талаар өмнөх онд зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 47 дугаар тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-р заалттай нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.	21.8	1. Гүйцэтгэх захирал, 2. Санхүүгийн газрын захирал	1. Б.Анхбаатар 2. Б.Наранцэцэг
4	"Монгол шуудан" ХК	"Монгол шуудан" ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг аудитын байгууллагад 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.	-	1. Гүйцэтгэх захирал, 2. Санхүүгийн газрын захирал	1. Б.Анхбаатар 2. Б.Наранцэцэг
5	"Монгол шуудан" ХК	2019 онд 15,506.7 сая төгрөгийн зардалтайгаар үйл ажиллагаа явуулж, зардлын төлөвлөгөөг 347.4 сая төгрөг буюу 102 хувиар	-	1. Гүйцэтгэх захирал, 2. Санхүүгийн	1. Б.Анхбаатар 2. Б.Наранцэцэг

		хэтрүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, 21 дүгээр зүйлийн 11-д “Төрийн өмчийн төлөөлөгч нь төлөөлөн удирдах зөвлөлтэй тухайн хуулийн этгээдийн хэтийн төлөвлөгөөг тохиролцож, түүний хэрэгжилтийг хянах...” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.		газрын захирал	
6	"Мэдээлэл, технологийн үндэсний парк" ТӨҮГ	Санхүүгийн тайланд бүртгэлтэй 6.7 сая төгрөгийн авлага нь 6-аас дээш жилийн хугацаатай барагдаагүй авлага байна.	6.7	1. Захирал, 2. Ерөнхий нягтлан бодогч	1. Э.Цогтгэрэл 2. Д.Цэрэндолгор
7	"Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ	"Тэнгэрийн эзэнт гүрэн" ХХК-д 2018 оны 5 дугаар сард хэмжүүрийн багаж худалдан авахаар 20 сая төгрөгийн урьдчилгаа олгосон нь төлөгдөөгүй зөрчил илэрсэн.	20.0	1. Захирал, 2. Санхүүгийн албаны дарга	1. С.Цагаанхүү 2. Б.Батмөнх
8	"Үндэсний дата төв" УТҮГ	Тендер зохион байгуулалгүй 35.2 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 9.9 сая төгрөгийн "Спорт наадамд ашиглах апплейкшн хөгжүүлэх" үйлчилгээг худалдан авсан байна.	35.9	1. Захирал, 2. Ерөнхий нягтлан бодогч	1. М.Баттулга 2. Д.Сүглэгмаа
9	Харилцаа холбооны зохицуулах хороо	Тайлант онд хорооны хурлын үйл ажиллагааны зардлыг 78.9 сая төгрөгөөр, хөтөлбөр арга хэмжээний зардлыг 34.4 сая төгрөгөөр нийт 113.3 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлсэн байна.	113.3	1. Дарга 2. Ерөнхий нягтлаг бодогч	1. Г.Чинзориг 2. Н.Халиунаа
<b>НИЙТ ДҮН</b>			<b>197.7</b>		
<b>ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ</b>					
1	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	Хуваарилах зорилгоор эзэмшиж байгаа 595.5 сая төгрөгийн анхны өртөгтэй, 503.1 сая төгрөгийн элэгдэлтэй нийт 8 ширхэг авто тээврийн хэрэгслийг эргэлтийн бус хөрөнгөд бүртгэсэн байна.	595.5	1. Дарга 2. Ахлах нягтлан бодогч	1. З.Мэндсайхан 2. Ж.Мөнхтүвшин
2	Үндэсний хөгжлийн газар	Нийслэлийн Баянзүрх дүүргийн 14 дүгээр сургуулийн барилгын концессын эргэн төлөлтийн үлдэгдэл 71.1 сая, Нийслэлийн Хан-Уул дүүргийн 32 дугаар сургуулийн барилгын концессын эргэн төлөлтийн үлдэгдэл 20.0 сая төгрөгийг өмнөх онуудад барьцаа хөрөнгийн дансанд татан төвлөрүүлсэн боловч Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтын I.1.1.6, I.1.1.7 дугаар хэсэгт дээрх төсөл, арга, хэмжээний зардлыг дахин баталсан байна.	91.1	1. Дарга 2. Ахлах нягтлан бодогч	1. Б.Баярсайхан 2. Г.Түвшинтөгс
3		Үндэсний хөгжлийн газар нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан	-	1. Дарга 2. Ахлах нягтлан бодогч	1. Б.Баярсайхан 2. Г.Түвшинтөгс

		цаглабарт хугацаанаас 3 хоногоор хоцроосон байна.			
4	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.	-	1. Дарга 2. Нягтлаг бодогч	1. Б.Чинбат 2.О.Наранбаатар
5		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний тусгай нөхцөлд нийт төсөвт өртгийн 10 хувийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулахаар заасан боловч нийт төсөвт өртгийн 5 хувийг байршуулсан байна.	191.1	1. Дарга 2. Нягтлаг бодогч	1. Б.Чинбат 2.О.Наранбаатар
6	МОНЦАМЭ агентлаг	Улсын мэдээний маягт хэвлэх ажил, үйлчилгээнд тендер зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн байна.	-	1. Дарга 2. Ерөнхий нягтлаг бодогч	1. Б.Ганчимэг 2. С.Золзаяа
<b>НИЙТ ДҮН</b>			<b>877.7</b>		
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН</b>					
1	Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сан	Харилцагч байгууллагатай 239.4 сая төгрөгийн авлага, 51.6 сая төгрөгийн өглөгийг тус тус тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	291.0	1. Дарга 2. Нягтлаг бодогч	1. Ч.Цогтгэрэл 2. Т.Халиунаа
2		БНҮҮС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд ашиглалтад орсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.	-	1. Дарга 2. Нягтлаг бодогч	1. Ч.Цогтгэрэл 2. Т.Халиунаа
<b>НИЙТ ДҮН</b>			<b>291.0</b>		
<b>НИЙТ АЛБАН ШААРДЛАГЫН ДҮН</b>			<b>1,366.4</b>		